



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 04 дүгээр сарын 29 өдөр Дугаар 43

Хэрлэн сум

XLIII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 43 дугаар хуралдаан 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 85 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Махны үнийн хөөрөгдлийн талаар мэдээлэл танилцуулах,  
Хүнс, хөдөө аж ахуйн газар
2. Чойлбалсан хотод үйл ажиллагаа эрхэлдэг "ЕF" хүнсний сүлжээ дэлгүүрт мах борлуулах цэг ажиллуулах талаар санал танилцуулах,  
Хүнс, хөдөө аж ахуйн газар
3. Худалдаа хөгжлийн банкнаас ирүүлсэн хүсэлт танилцуулах,  
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г. Нармандах,  
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ж. Алимаа нарт:



1.1. Дорнод аймгийн хэмжээнд махны үнийн хөөрөгдлийг бууруулах зорилгоор 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 07-ны өдрийг дуустал хугацаанд Дорнод аймгаас Нийслэл Улаанбаатар болон бусад аймаг руу хүнсний зориулалтаар амьд мал, мах тээвэрлэх хөдөлгөөнийг хориглох тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ж. Алимаа-д:

1.2. Махны үнийн хөөрөгдлийг бууруулах зорилгоор Дорнод аймгаас Нийслэл Улаанбаатар болон бусад аймаг руу хүнсний зориулалтаар амьд мал, мах тээвэрлэх хөдөлгөөнийг 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 07-ны өдрийг дуустал хугацаанд хориглох тухай албан бичгийг Хүнс, хөдөө аж ахуйн сайдад албан бичиг хүргүүлэх,

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойлбалсан хотын захирагч,  
Онцгой комиссын гишүүн О. Пүрэв-Очир-д:

1.3. Дорнод аймгаас Нийслэл Улаанбаатар болон бусад аймаг руу хүнсний зориулалтаар амьд мал, мах тээвэрлэх хөдөлгөөнийг 2021 оны 05 дугаар сарын

/  /М.Бадамсүрэн  
/  /Д.Баттулга

01-ний өдрөөс 05 дугаар сарын 07-ны өдрийг дуустал хугацаанд хориглох шийдвэр гарсан тухай Чойбалсан хотод мах боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд албан бичгээр мэдэгдэх,

Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын  
гишүүн, ерөнхий зохицуулагч нарт:

1.4.Дорнод аймгаас Нийслэл Улаанбаатар болон бусад аймаг руу хүнсний зориулалтаар амьд мал, мах тээвэрлэх хөдөлгөөнийг 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 07-ны өдрийг дуустал хугацаанд хориглох шийдвэр гарсан тухай иргэдэд мэдээлэх,

Хоёр.АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн Цэнгэлмаа,  
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ж.Алимаа нарт:

2.1. “ЕF” хүнсний сүлжээ дэлгүүрийн мах борлуулах цэгт борлуулалтын ажилтныг ажиллуулахад шаардагдах зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах

Шуурхай штабын гишүүн, ерөнхий зохицуулагчид:

2.2.Дорнод аймгаас бусад аймаг руу зорчих хүсэлтэй иргэд ПГУ/PCR/-ын шинжилгээнд хамрагдаж зорчих талаар иргэдэд мэдээлэх,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга,  
Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий,  
АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ,  
АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа нарт:

2.3.Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын “Call center” багт оператороор ажиллах төрийн байгууллагын албан хаагчдыг судалж, саналыг аймгийн Шуурхай штабын хуралд танилцуулах,

Гурав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.1.Худалдаа хөгжлийн банкны Дорнод салбараас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийн дагуу аймгийн Онцгой комиссын 2021 оны “Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай” 46 дугаар тогтоолд Худалдаа хөгжлийн банкны Дорнод салбарыг тусгай горимоор ажиллуулах тухай нэмэлт өөрчлөлт оруулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГА М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА Д.БАТТУЛГА

